

БАТЛАВ. “БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУИ  
ОРЧНЫ, БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ  
ХҮЛЭЭСЭН:  
“МОНЖИН ДАЛАЙ” ХХК-ИЙН

.....**Ж.ЭНХМӨНХ**

**ЗАХИРАЛ:**.....**Л.ПҮРЭВДАВАА**

**“МОНЖИН ДАЛАЙ” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН ЗААМАР  
СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-014506 ТООТ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ЦАГААН БУЛАГИЙН АЛТНЫ  
ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-014506

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2851326

**ХЯНАСАН:**

БОАЖЯ, ХБОБЗГ-ын ахлах мэргэжилтэн: .....**Ц.ЖАРГАЛНЭМЭХ**

**БОЛОВСРУУЛСАН:**

“Монжин далай” ХХК-ийн БО-ны мэргэжилтэн.....**Б.БОЛДТӨМӨР**

**УЛААНБААТАР ХОТ  
2024 он**

## ГАРЧИГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	3
БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	4
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.2 “Цагаан булаг”-ийн алтны шороон ордын нөөц .....	5
1.3 Ил уурхайн жилийн хүчин чадал болон ажиллах хугацаа .....	6
1.4 Овоолгын төлөвлөгөө .....	8
1.5 Баяжуулалтын технологи .....	8
1.6 Хаягдлын далан.....	8
БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
БҮЛЭГ III. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	10
3.1 Сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	10
3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	11
3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	13
3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	14
3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	14
3.6 Болзошгүй эрсдлээс хамгаалах менежментийн төлөвлөгөө.....	15
3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	15
3.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	17
3.9 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	17
3.10 Тухайн жилийн БОМГ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар.....	20

**Хүснэгтийн жагсаалт:**

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэг / MV-014506/ .....	4
Хүснэгт 2. Үйлдвэрлэлийн нөөц-1 .....	5
Хүснэгт 3. Үйлдвэрлэлийн нөөц-2 .....	5
Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим .....	6
Хүснэгт 5. Төслийн техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт .....	7
Хүснэгт 6. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгдсэн дүн .....	10
Хүснэгт 7. 2024 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	11
Хүснэгт 8. Болзошгүй эрсдлээс хамгаалах зардал .....	15
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	17
Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал .....	18
Хүснэгт 11. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь .....	19

**Зургийн жагсаалт:**

Зураг 1. Төслийн талбайн зураг .....	4
Зураг 2. Ил уурхайн хүрээ хязгаар .....	6
Зураг 3. Төслийн гол сөрөг нөлөөлөлт .....	9

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Уг төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах боломж бүрдэхээс гадна төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлж, эдийн засгийн үр ашиг нэмэгддэг.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээлгэн өгч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.

Энэхүү төлөвлөгөөгөөр Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-014506 тоот тусгай зөвшөөрөл бүхий Цагаан булагийн алтны үүсмэл шороон ордыг ашиглах үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй болон голлох сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно. Уг төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулж тусгай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллавал илүү үр дүнтэй байх болно. Мөн төлөвлөгөөг орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнтэй уялдуулж, жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай.

## 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

**Төслийн нэр:** Цагаан булаг

**Төсөл хэрэгжүүлэгч:** "Монжин далай" ХХК


**Улсын бүртгэлийн дугаар:** 9011352018

**Регистрийн дугаар:** 2851326

**Хаяг, байршил:** Улаанбаатар, Баянгол, 7-р хороо, 4-р хороолол, Ард аюушийн өргөн чөлөө, 65/2-3 тоот

**Утас:** 99000787, 80112201

**Ашиглах талбай:** MV-014506 160 га



Зураг 1. Төслийн талбайн зураг

“Цагаан булаг” нэртэй 160 га бүхий МУ-014506 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, “Шижир алт” суурингаас 3 км зайд, байр зүйн зургийн М-48-126 нэрэлбэрт орших ба талбайн булангийн цэгүүдийн газар зүйн солбилцолыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэг / MV-014506/

№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	104°	33'	55.32 <sup>11</sup>	48°	24'	3.47 <sup>11</sup>
2	104°	32'	41.58 <sup>11</sup>	48°	24'	3.47 <sup>11</sup>
3	104°	32'	41.01 <sup>1</sup>	48°	24'	47.1 <sup>11</sup>
4	104°	33'	55.32 <sup>11</sup>	48°	24'	27.93 <sup>11</sup>

“Монжин далай” ХХК нь 2019 онд өөрийн хөрөнгөөр Цагаан булагийн ордод нарийвчилсан хайгуулын ажил хийсэн бөгөөд тус ажлын үр дүнгээр алтны нөөцийн хэмжээг тогтоосон байна. Хайгуулын ажлын явцад III зэрэглэлийн С бүлгийн 3 хэсэглэлийг нээж тогтоосон байна.

Цагаан булагийн алтны үүсмэл шороон ордод өмнө нь олборлолт явуулж байсан бөгөөд хаягдалын овоолго дээр дахин хайгуул хийж эдийн засгийн хувьд ашигтай нөөцийг тогтоосон. Хөрс хуулалтын хэмжээ харьцангуй багатай бөгөөд элсийг авто тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглахаар төсөлд тусгасан.

## 1.2 “Цагаан булаг”-ийн алтны шороон ордын нөөц

**Хаягдал, бохирдлын тооцоо:** Тус ордыг ашиглах үед хаягдал үүсгэхгүйгээр тооцсон ба бохирдлыг тооцохдоо алт агуулагч элсний ул ба таазнаас тус бүр 20 см бохирдуулж авахаар тооцоолсон.

Хүснэгт 2. Геологийн нөөц-1

Нөөцийн зэрэг, Хэсэгшлэлийн дугаар	Зузаан,м		Хэсэглэл- ийн талбай мян.м <sup>2</sup>	Эзлэхүүн, мян.м <sup>3</sup>		Алтны нөөц, кг /шлихээр/	Дундаж агуулга, мг/м <sup>3</sup>	Алтны нөөц, кг /хим.цэв/
	Хөрс	Элс		Хөрс	Элс			
С-1	1.3	5.1	6.7	8.9	34.5	4.102	119	3.522
С-2	1.2	5.6	6.3	7.7	34.5	4.188	122	3.597
С-3	1.2	5.9	4.6	5.5	27.1	3.553	131	3.051
<b>Ордын нийт, дундаж</b>	<b>1.3</b>	<b>5.5</b>	<b>17.6</b>	<b>22.1</b>	<b>96.1</b>	<b>11.843</b>	<b>123</b>	<b>10.171</b>

**Тайлбар:** АМГТГ-ын даргын 2020 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн Н/23 дугаар тушаалаар улсын бүртгэлд бүртгэсэн геологийн нөөц дээр үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог хийхдээ Уул уурхайн сайдын 2015 оны 09-р сарын 11 -ний өдрийн 203 тоот тушаалын хавсралт “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын дагуу уг орд нь III бүлэгт хамаарч байгаа тул С зэргийн нөөцүүдийг үйлдвэрлэлийн магадлагдсан В’ зэрэг ишилжүүлэн тооцсон болно. Уг нөөцийг ашиглах үед хаягдалгүй олборлохоор төлөвлөсөн ба элсийг ул болон таазнаас 20 см бохирдуулахаар тооцоолсон.

Хүснэгт 3. Үйлдвэрлэлийн нөөц-2

Үйлдвэрлэлийн нөөцийн блокийн дугаар	Ашиглалтын үеийн бохирдол				Үйлдвэрлэлийн нөөц				
	Хувь	Тааз, мян.м <sup>3</sup>	Ул, мян.м <sup>3</sup>	Нийт бохирдол, мян.м <sup>3</sup>	Хөрсний хэмжээ, мян.м <sup>3</sup>	Элсний хэмжээ, мян.м <sup>3</sup>	Дундаж агуулга, мг/м <sup>3</sup>	Металл шлих, кг	Металл х.ц, кг
В'-1	8.0	1.37	1.37	2.75	7.56	37.25	110	4.10	3.52
В'-2	7.2	1.24	1.24	2.48	6.20	36.98	113	4.19	3.60
В'-3	6.8	0.92	0.92	1.84	4.60	28.94	123	3.55	3.05
<b>Дүн</b>	<b>7.4</b>	<b>3.53</b>	<b>3.53</b>	<b>7.07</b>	<b>18.36</b>	<b>103.17</b>	<b>115</b>	<b>11.84</b>	<b>10.17</b>

**Ил уурхайн хүрээ хязгаар:** Геологийн нөөцийн хайгуулын ажлаар тогтоогдсон 96 мян.м<sup>3</sup> элсийг хаягдалгүйгээр бүрэн олборлоно. Ашиглалтын явцад ил уурхайн хүрээнд 18.36 мян.м<sup>3</sup> хөрс, 103.17 мян.м<sup>3</sup> элс орж байна. Хөрс хуулалтын коэффициент ордын хэмжээнд 0.18 м<sup>3</sup>/м<sup>3</sup> байна. Уурхайн хүрээний нийт урт 637 м, уурхайн урт 236 м, уурхайн өргөн 115 м, газрын гадаргаас хамгийн гүн хэсэгтээ 14 м, хамгийн нам хэсэгтээ 4.9 м, дунджаар 7.4 м гүнтэй ил уурхай үүснэ.



Зураг 2. Ил уурхайн хүрээ хязгаар

### 1.3 Ил уурхайн жилийн хүчин чадал болон ажиллах хугацаа

**Уурхайн хүчин чадал, ажиллах горим:** Цагаан булагийн алтны үүсмэл шороон орд 5-р сараас эхлэн ажиллана. Уулын ажил хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Монгол улсын хөдөлмөрийн хуулинд заасны дагуу жилд амрах баяр ёслолын хоног цаг болон техникийн саатал гарах эрсдлийг тооцон 315 хоног ажиллахаар тооцлоо. Монгол улсын хөдөлмөрийн хуулинд заасны дагуу жилд амрах баяр ёслолын хоногт ажилласан ажилчдын цалинг хуулийн дагуу нэмэгдэлтэй олгохоор төсөлд тусгасан.

Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим

Ашиглалтын жил	Сар	Сарын хоног	Баяр ёслол	Техникийн саатал	Сард ажиллах хоног
2-р жил	6	30	2		28
	7	31	5		26
	8	31		3	28
	9	30	-		30
	10	31	-	1	30
3-р жил	5	31	-		31
	6	30	2		28
	7	31	5		26
	8	31	-	3	28
	9	30	-		30
	10	31	-	1	30

Геотехникийн саатлыг тооцохдоо "Монжин далай" ХХК-ийн техникүүдийн өнгөрсөн онуудад ажилласан мото-цаг болон засвар үйлчилгээний графикт үндэслэн төсөлд тусгасан.

Хүснэгт 5. Төслийн техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн
1	Төсөл хэрэгжүүлэгч компани	“Монжин далай” ХХК	
2	Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар		
3	Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-014506	
4	Ашигт малтмалын төрөл	Алт	
<b>ГЕОЛОГИЙН НӨӨЦ (С ЗЭРГЭЭР)</b>			
5	Элсний хэмжээ. Боломжтой (С)	мян.м <sup>3</sup>	96.1
6	Алтны нөөц. Боломжтой (С) шлихээр	кг	11.84
7	Алтны нөөц. Боломжтой (С) химийн цэврээр	кг	10.17
<b>ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ</b>			
8	Элсний хэмжээ	мян.м <sup>3</sup>	103.17
9	Ашиглалтын технологи	Ил уурхайн автотээвэртэй ашиглалтын систем	
10	Хүчин чадал	мян.м <sup>3</sup>	60
14	Бохирдол	%	7.35
15	Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр	м <sup>3</sup> /м <sup>3</sup>	0.18
17	Орд ашиглалтын хугацаа	жил	2
18	Цахилгааны эх үүсвэр	Төвийн эрчим хүчний систем	
19	Усан хангамжийн эх үүсвэр	Үүсмэл нуур	
<b>БАЯЖУУЛАХ ЦЕХ</b>			
20	Баяжуулах технологи	Гравитаци, хүрдэн шигшүүр, гүн болон нам дүүргэлтийн шлюз, сэгсрэх ширээ	
21	Хүчин чадал /ашиглалтын жилийн дунджаар/	мян.м <sup>3</sup> /жил	60
22	Бүтээгдэхүүн гаргалт: Металл авалт	%	83.7
	Алтны хэмжээ	кг	8.51
23	Хаягдал гаргалт: Галийн гарц +20 мм-с дээш ангилал	%	58.02
	Эфелийн гарц -20 мм-с доош ангилал		41.37
	Галийн хэмжээ	мян.м <sup>3</sup>	59.8
	Эфелийн хэмжээ		43.25
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
24	1 унци алтны үнэ	ам.доллар/унци	1,750.00
25	1 унци алтны бүрэн өөрийн өртөг	ам.доллар/унци	985.7
26	1 гр алтны бүрэн өөрийн өртөг	мян.төг/гр	85.6
27	1 м <sup>3</sup> элсэнд ногдох зардал	мян.төг/м <sup>3</sup>	7.06
28	Хөрөнгө оруулалт	сая/төг	249.5
29	Өнөөгийн үнэ, цэнэ NPV @ 10%	сая/төг	26.8
30	Өгөөжийн дотоод норм, ИКК	%	11.8
31	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	сар	6
32	Улсын төсөвт оруулах татвар, төлбөр (ордын нийт)	сая/төг	139.0
33	Нийт ажиллагсдын тоо	хүн	23
34	Нэг ажилчны сарын дундаж цалин	мян.төг/сар	<b>1,226.7</b>
35	Цэвэр ашиг	сая.төг	<b>507.0</b>



#### 1.4 Овоолгын төлөвлөгөө

**Шимт хөрсний овоолго:** Тус талбайд өмнө нь олборлолт явуулж байсан бөгөөд нийт 71 га газар өмнөх олборлолтын явцад эвдэгдэж техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна. 2019 оны хайгуулын ажлаар тогтоогдсон хэсэгт шимт хөрс байхгүй тул шимт хөрсний хэмжээг тооцоолоогүй болно.

**Хөрсний дотоод овоолго:** Орд нь хэвтээ хэвгий уналтай мөн хөрс хуулалт бага байгааг харгалзан элс олборлолтын ажилтай уялдуулан уурхайн ашиглагдсан хоосон орон зайд хөрсний дотоод овоолго үүсгэхээр төсөлд тусгасан. Хөрсний дотоод овоолгод ашиглалтын хугацаанд нийт 18.36 мян.м<sup>3</sup> хөрс овоолно. Ашиглалт явуулах 3 жилийн хугацаанд нийт 60 мян.м<sup>3</sup> орчим гааль гарах бөгөөд тус хаягдалыг мөн уурхайн ашиглагдсан хоосон орон зайд дотоод овоолго хэлбэрээр байршуулна.

#### 1.5 Баяжуулалтын технологи

Алтны үүсмэл шороон ордын ашигт давхарга нь линз маягаар баруун хойш сунаж тогтсон ба алт агуулагч ашигт давхаргын зузаан 4.4 м буюу 6.4 м-ээс хүртэл хэлбэлзэнэ. Ашигт давхаргын дээд хэсэгт дотоод овоолго хийгдсэн шар, улаан өнгийн шаварлаг хурдас (0.0-2.0 м) байрлах ба энэ суларсан шаварлаг хурдасаас доош ул чулуу хүртэл хуучин баяжуулагдсан элсний овоолго (4.4-6.4 м) ёроол буюу ул чулууны дээр байрлана. Ашигт давхарга нь олон салаалаагүй энгийн тогтоцтой. Орд нь нэг ашигт давхаргаас бүрддэг.

Цагаан булагийн алтны үүсмэл шороон ордын 593.7 кг дээжид 2019 оны 10 сард Шинжлэх ухааны академи хими, химийн технологийн хүрээлэн эрдсийн технологийн лабораторид баяжуулах технологийн туршилтыг хийсэн. Ордоос технологийн туршилтад авсан дээж нь дунд зэргийн угаагдах шинж чанартай, үндсэн баяжуулалтад шлюз, гүйцээн баяжуулах шатанд сэгсрэх ширээ ашигласнаар 83.7 %-ийн металл авалттай баяжуулах боломжтой нь тогтоогдсон байна.

#### Хүчин чадал төлөвлөлт

Цагаан булагийн алтны үүсмэл шороон ордын алт агуулсан элсийг угаан баяжуулах үйлдвэр нь уурхайгаас тэжээх элсний хэмжээнээс хамаарч угаалтын ажлын хэмжээ харилцан адилгүй байна. Элс угаах үйлдвэр нь улиралын чанартай үйл ажиллагаа явуулах бөгөөд төлөвлөгөөт засвар болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээ, техник тоног төхөөрөмж ашиглалт мөн төсөл захиалагч байгууллагын тоног төхөөрөмжүүдийг тусгасан бөгөөд төслийн хугацаа 2 жил байна.


#### 1.6 Хаягдлын далан

Шороон ордын элсийг угаах усны санг уурхайн ашиглагдсан талбайд уурхайгаас гадагш орших талбайд байгуулах хувилбарууд бий. Шороон ордын онцлог ба усны эх үүсвэрийн нөхцөлөөс хамаарч усан сан байгуулах түүний багтаамжийг тогтоох техник хангамж, эргэлтийн ба нөхвөрлөх усны систем бүрдүүлэх ажлууд хийгддэг.

Алт агуулсан элсийг угаах скрубберийн тоног төхөөрөмжийг +948 м-ийн түвшинд суурьлуулахаар төлөвлөсөн. Хаягдал буюу эфель нь өөрийн урсгалаар урсан тунаах санд орж хуримтлагдана. Тунаах далангийн суурийн доод түвшин +943 м-т байна.

## БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Алтны үүсмэл шороон орд ашиглах төслийн хөрс хуулалт, элс тээвэрлэлт, элс баяжуулах зэрэг үйл ажиллагаанаас агаарын чанар, газрын гадарга, усан орчин, ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч болон амьтны аймагт сөргөөр нөлөөлөхөөр байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нийт 55 нөлөөллөөр тооцов. 15 буюу 27% нь бага, 21 буюу 38% нь дунд, 13 буюу 24% нь их, 6 буюу 11% нь их гэсэн нөлөөллийн ангилалд багтаж байна. Үүнээс үзэхэд төслөөс байгаль орчинд дундаас их нөлөөлөл үзүүлэхээр байна.



Зураг 3. Төслийн гол сөрөг нөлөөлөлт

Тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг даган мөрдөж, уурхай ашиглалт дууссаны дараагаар нөхөн сэргээлтийн арга хэмжээг зохих стандартын дагуу хэрэгжүүлснээр сөрөг нөлөөллийг зохих түвшинд барих бүрэн боломжтой.

### Хуримтлагдах нөлөөллийн асуудал

АҮШООУ төсөл хэрэгжих явцад хуримтлагдах нөлөөлөл, хам нөлөөлөл үүсгэх төслүүдэд АҮШООУ төсөлтэй зэрэгцэн хэрэгжиж буй алтны бусад уурхай ба тэдгээрийн дагалдах хуучин уурхайн тосгон, багийн төвийн суурин, орон нутгийн хөрсөн зам зэрэг барилга объект, үйл ажиллагаанууд хамаарна. Эдгээр төслүүдийн өөр хоорондоо харьцангуй байршил нь 5.0-25.0 км зайд хэлбэлзэх ба газрын хамрах хүрээний хувьд ерөнхий дүнгээр 500-700 орчим га талбайг эзэлнэ.

## БҮЛЭГ III. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 3.1 Сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Монжин далай” ХХК нь 2024 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт 9.60 сая төгрөг зарцуулахаар төлөвлөв. ТЭЗҮ-ийн дагуу биологийн нөхөн сэргээлтийг энэ жил 1.2 га талбайд хийхээр төлөвлөж байна. Энд тусгагдаагүй зардлууд нь уулын ажлын болон хөдөлмөр хамгаалалын зардалд тусгагдсан болно. Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль хамгаалагч болон БОХГ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 6. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгдсэн дүн

д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Хөрөнгийн хэмжээ, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	мян. төг	0.100
2	Нөхөн сэргээлтийн зардал	мян. төг	2.200
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	мян. төг	2.300
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	мян. төг	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	мян. төг	
6	Болзошигүй эрсдлээс хамгаалах зардал	мян. төг	0.100
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	мян. төг	0.200
8	Удирдлага-зохион байгуулалтын болон бусад арга хэмжээ	мян. төг	
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	мян. төг	1.200
10	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод	мян. төг	3.500
11	БОМТ-г орон нутагт тайлагнах	мян. төг	
	<b>Дүн</b>		<b>9.600</b>

### 3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. 2024 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
<b>1</b>	<b>Агаарын чанар</b>								
	Ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөс ялгарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Хуурайшилттай үед гадаад ба дотоод тээврийн замыг услаж тоосжилтыг бууруулж байх	Уурхайн дотоод болон гадаад шороон зам	га	Үйл ажиллагааны зардалд			7 хоногт 1-2 удаа	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS48 5013:2009 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Машин механизмаас гарах утаанд хяналт тавих	Төсөлд хэрэгжүүлэхэд ашиглах бүх дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, машин механизм	ш	Үйл ажиллагааны зардалд			2024 оны турш тогтмол	
		Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавих		-	Үйл ажиллагааны зардалд			2024 оны турш тогтмол	
		Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлах тэмдэг тэмдэглэгээг сайжруулах		ш			250 000	2024 оны турш тогтмол	
<b>2</b>	<b>Гадаргын ба газрын доорхи усны нөөц</b>								
	Төслийн үйл ажиллагааны ус хэрэглээнээс үүсэх газрын доорх усны түвшний бууралт, газрын доорх усны нөөц багасах	Ус ашиглах дүтнэлт гаргуулах	Гүний усанд	-	Үйл ажиллагааны зардалд			2024 онд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт -Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
		Олборлолтын үед ашиглах усны төлбөр тооцоог холбогдох байгууллагад төлөх		шоо метр	-			Гэрээний дагуу төлбөр төлөх	

3 Хөрс, үргамлан бүрхэвч									
Уурхайн нөлөөллийн бүсийн хүрээнийзам талбайн тохижилт муугаас үүдэн машин техник, хүний хөлөөр хөрсөн бүрхэвч доройтох	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд ЯВУУЛЖ хэвших	Төслийн ойр орчин	-	-	-	-	2024 онд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль • Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.	
	Уурхайн комп орчимд НОГООН байгууламж байгуулах, арчлах	Үйлдвэр болон уурхайн орчимд	м.кв	-	-	250 000	2024 онд	Техникийн шаардлага MNS 5915:2008, • Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага MNS 5916:2008, • Эвдэрсэн газрыг Ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918: 2008, • Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс MNS 4919: 2000, • Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага MNS 4920: 2000.	
4 Амьтны аймаг									
Ан амьтан дайжих, тоо толгой хорогдох	Ан амьтны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-аас танилцуулах самбар, постер хийх	Төслийн талбай орчмын ан амьтад	ш	Үйл ажиллагааны зардалд			2024 онд	Амьтны тухай хууль	
<b>Нийт</b>						<b>500 000</b>			

### 3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго	га	1.4	-	2 200 000	2024 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
<b>Нийт</b>						<b>2 200 000</b>		

### 3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1	Хаягдсан газарт техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэржүүлэх	Эвдэрч эзэнгүй орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын түвшинд гүйцэтгэх	Заамар сумын нутаг дэвсгэрт	5.0 га	-	2 300 000	2024 онд	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас өгсөн зөвлөмжийн дагуу
2	“1 тэрбум мод” үндэсний хөтөлбөр	Сум орон нутгийн хэмжээнд ойжуулах талбайд элсний нүүдлийг сааруулах, зогсоох, мөн ойжуулалтын талбайд тарималжуулах	Төв аймаг ба Заамар сумын ойжуулах талбайд	500 ш	7000	3 500 000	2024 онд	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол
<b>Нийт</b>						<b>5 800 000</b>		

### 3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нөхөн олговор олгох арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1								
2								
3								
<b>Нийт</b>								

### 3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөлийн бусад яман нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олоход үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох башууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1	Археологийн дурсгал							
2	Палеонтологийн дурсгал							
<b>Нийт</b>								

### 3.6 Болзошгүй эрсдлээс хамгаалах менежментийн төлөвлөгөө

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанд ямарваа нэг химийн бодис ашигладаггүй нь химийн бодисоос үүсэх эрсдэлгүй тул болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөөг боловсруулж өглөө.

Хүснэгт 8. Болзошгүй эрсдлээс хамгаалах зардал

№	Болзошгүй аюул, осол, сөрөг, нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Болзошгүй эрсдлээс хамгаалсан сургалт зохион байгуулах	Төслийн хүрээнд	1	100 000	100 000	2 удаа	Гамшгаас хамгаалах тухай, 27-р зүйл Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS 5566:2005 MNS 0640:89 MNS 639:89
2	Гал түмрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Аюул тохиолдсон газрыг хамгаалалтанд авч, хор аюулын таних тэмдэглэгээг байршуулж холбогдох мэргэжлийн байгууллагыг дуудан туслалцаа авах	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардал		2024 онд		
3		Галын хорыг шалгаж, шаардлага хангахгүй хорыг сольж, шинэчлэн цэнэглэж байршуулах	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардал		2024 онд		
	Шатах тослох материалын асгаралт	Шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардал		2024 онд		
<b>Нийт</b>						<b>100 000</b>		

### 3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
1	Ахуйн	Хог хаягдлын төрөл тус бүрээр ангилан ялгаж, түр хадгалах цэгийг хашаа хамгаалалт хийж, тохижуулах	Уурхайн тосгон	-	Үйл ажиллагааны зардалд			2024 онд	Хог хаягдлын тухай хууль, 10-р зүйл Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн А-116 дугаар тушаалын хавсралт
		Дахин ашиглагдах хаягдлыг хоёрдогч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх. /хуванцар сав, шингэн хаягдал /	Уурхайн тосгон	-	Үйл ажиллагааны зардалд			2024 онд	
		Шаардлага хангасан цэгт төвлөрүүлж орон нутагтай хог ашиглалтын гэрээ хийж зайлуулна.	-	-	-	-	50 000	2024 онд	



№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлөл хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Үйлдвэрлэлийн	Хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг чөлөөт урсацаас чөлөөлж нэг цэгт төвлөрүүлэх	Уурхай	кг	Үйл ажиллагааны зардалд			2024 онд	MNS 5450:2019 MNS 5344 : 2011 MNS 180 11074-1 : 2001
3	Аюултай	Аюултай хог хаягдлын цэгийн татбайг цэвэрлэж засаж, тохижуулах, асгаралт үүсэхээс хамгаалах	Аюултай хог хаягдлыг хадгалах талбайд	м.кв	Үйл ажиллагааны зардалд			2024 онд	Хог хаягдлын тхай хууль 22, 23, 24-р зүйл,
		Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний явцад гарсан аюултай хог хаягдлыг контейнерг хадгалах /аккумулятор, баттерей ашиглагдсан шатах тослох материал, тос маслын сав г.м./	Төслийн хүрээнд	кг	Үйл ажиллагааны зардалд			2024 онд	
		Ашиглагдсан шатах тослох материалыг битүү саванц хадгалж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.	-	л	-	-	150 000	2024 онд	
<b>Нийт</b>							<b>200 000</b>		

### 3.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь 2024 он			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Сар	Сар	Сар		
	1.	2.	3.	4.	5.	6.	7.
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг ажилчдад хийх	200 000	6 сар	10 сар	-	Байгаль орчны мэргэжилтэн	Галын аюулгүй ажиллагааны дүрэм
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбарыг уурхайн кэмп, төв хаалга, уурхайлалтын бүсэд байрлуулах, шинэчлэх	200 000				Байгаль орчны мэргэжилтэн	Байгаль орчныг Хамгаалах тухай хууль
3	Байгалийн нөөц ашигласны төлбөр хураамжийг цаг хугацаанд нь төлөх	Үйл ажиллагааны зардалд			11 сард	Монжин далай ХХК	
4	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх	Гэрээний үнэн дүнгээр		8 сард			
<b>Нийт</b>		<b>400 000</b>					

### 3.9 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Монжин далай” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

“Монжин далай” ХХК -ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших Алтны үүсмэл шороон ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэхэд дээрх аргачлалын дагуу “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” -ийг явуулах үүрэгтэй бөгөөд гаргах зардлыг тус компани нь бүрэн хариуцна.

Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ-н харьяа БОХЛ, Геологийн төв лаборатори, Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори болон УСУГ-н усны лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

*Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал/*

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1.	2.	3.	4.	4.	6.	7.
1	<b>Агаарын чанар</b>						
	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд / Уурхайн олборлолт болон үйлдвэрийн ойролцоо талбайд/	8 сар	Жилд 1 удаа 2 цэгт	Томилолт-250.0 Шинжилгээний зардал- 150.0	450 000	MNS 6585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Байгаль хамгаалал. Агаар мандал. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11 1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотэколориметийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга. MNS 5014:2000 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм,
	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн олборлолт болон үйлдвэрийн ойролцоо талбайд 2 цэг	8 сар	Жилд 1 удаа 2 цэгт	Шинжилгээний зардал - 100.0	200 000	
2	<b>Хөрсний бохирдол</b>						

	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн. нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Төслийн талбайд 2 цэг товлох ШТМ түгээх цэгийн орчим - карьер орчим - шимт хөрсний овоолго	8 сар	Жилд 1 удаа 3 цэгт	Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -100.0 төг.	300 000	MNS 3307:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Дээрх 3 цэгт	8 сар	Жилд 1 удаа 3 цэгт	хүнд металлын шинжилгээ 1 дээж- 50.0 төг	150 000	
3	<b>Усны шинжилгээ</b>						
	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Гүний худаг	8 сар	Жилд 1 удаа	100.0 төг	100 000	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900: 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
<b>Нийт</b>						<b>1 200 000</b>	

### 3.10 Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар

Хүснэгт 11. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал (төгрөг)	Хариуцан зохион Байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1.	2.	3.	4.	5.	6.	7.
1	Иргэдийн Нийтийн Хуралд	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холтбоотой фото зургаар баталгаажсан байна.	10 сард	Үйл ажиллагааны зардалд	Байгаль орчны мэргэжилтэн	Заамар сум
2	Аймгийн байгаль орчны газарт	хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр		11 дүгээр сарын 01-ний дотор	Үйл ажиллагааны зардалд	Байгаль орчны мэргэжилтэн	Төв аймаг
3	Байгаль Орчин Аялал Жуулчлалын яам	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт		Жилийн эцэст (12.01-нд)	Үйл ажиллагааны зардалд	Байгаль орчны мэргэжилтэн	Улаанбаатар хот